



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (400)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Бүгд Найрамдах Франц Улсын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *“Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал”-д нэгдэн орох тухай*
- *Ажилд томилох тухай*
- *Тогтоолд нэмэлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны тавдугаар сарын 21

№19 (400)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

706.	Бүгд Найрамдах Франц Улсын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 81	422
707.	Жой Спурлокийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 82	422

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

708.	Жагсаалт батлах тухай	Дугаар 251	422
709.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 76	424
710.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 78	425
711.	"Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал"-д нэгдэн орох тухай	Дугаар 79	425
712.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 80	426
713.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 84	426
714.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 85	426
715.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 86	426
716.	Ажилд томилох тухай	Дугаар 87	427
717.	Ажилд томилох тухай	Дугаар 88	427
718.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 93	427



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Бүгд Найрамдах Франц Улсын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тохиолдуулан тус хоёр орны уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Франц Улсын дор дурдсан иргэдийг одон, медалиар шагнасугай.

“Алтан гадас” одонгоор:

Жак-Жан Ив Легран-Бүгд Найрамдах Франц Улсын Дорно дахины хэл, соёл иргэншлийн үндэсний дээд сургуулийн ерөнхийлөгч

“Найрамдал” медалиар:

1. Франсуаз Обен -Монгол судлаач, ахмад эрдэмтэн

4. Жан-пол Дерош -Парисын Азийн урлагийн үндэсний “Гиме” музейн захирал, Архангай аймгийн “Гол мод”-ны Монгол, Францын хамтарсан археологийн экспедицийн францын талын ахлагч

2. Роберт Амаяон-Парисын Сорбоны их сургуулийн Монгол, Сибирь судлалын төвийн эрхлэгч

3. Мари Доминик Эвен-Монгол-Францын найрамдлын “Анд” нийгэмлэгийн тэргүүн

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Жой Спурлокийг “Найрамдал” медалиар шагнах тухай

Монгол Улсын шүүгч, хуульчдын мэргэшлийг дээшлүүлэх, шүүхийн шинэтгэлд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АНУ-ын Техас мужийн Уэслианы их сургуулийн профессор, Азийн дээд сургуулийн захирал Жой Спурлокийг

“Найрамдал” медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

1. “Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшлийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

2. Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшлийн жагсаалтыг 3 жил тутам хянан үзэж, Засгийн газарт саналаа танилцуулан холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж байхыг

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДСРЖ

МОНГОЛ УЛСАД ОНЦ ШААРДЛАГАТАЙ МЭРГЭЖИЛ, МЭРГЭШЛИЙН ЖАГСААЛТ

- | | |
|---|--|
| 1. Анагаах ухааны салбарт: | 3.1. мэдээлэл боловсруулах математикийн программ зохиогч; |
| 1.1. цээжний хөндийн мэс заслын их эмч; | 3.2. мэдээллийн технологийн математик загвар, алгоритмын программ зохиогч; |
| 1.2. мэдрэлийн мэс заслын их эмч; | 3.3. богино, дунд, урт хугацааны прогнозын математикч; |
| 1.3. үе дурандах, үе солих мэс заслын их эмч; | 3.4. нанотехнологийн электрон инженер; |
| 1.4. нөхөн сэргээх мэс заслын их эмч; | 3.5. мэдээлэл, түүнийг алсад дамжуулах сансрын техникийн инженер; |
| 1.5. эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын их эмч; | 3.6. системийн судалгааны мэргэжилтэн. |
| 1.6. цөмийн онош зүйн эмч; | 4. Геологи, газар зүйн салбарт: |
| 1.7. харшил судлаач их эмч; | 4.1. эрэл зураглалын геологич инженер; |
| 1.8. анагаах ухааны нанотехнологич; | 4.2. газар хөдлөл судлалын инженер; |
| 1.9. эм зүйн нанотехнологич. | 4.3. геодезийн тоон зураглалын технологийн инженер; |
| 2. Физик, хими, биологийн салбарт: | 4.4. ул хөрсний геодезист. |
| 2.1. Физик: | 5. Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт: |
| 2.1.1. цөмийн цацраг, хэт ягаан туяаны тархалт судлалын инженер; | 5.1. хүнсний төрөл бүрийн халдвар үүсгэгчийн ген судлаач; |
| 2.1.2. сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр (нар, салхи, ус г.м)-ийг ашиглах техник, технологийн инженер; | 5.2. мал, амьтны өвчин үүсгэгчийн молекулын генетикч; |
| 2.1.3. дулааны эрчим хүчний инженер; | 5.3. мал, амьтны хөврөл үр, ген шилжүүлэн суулгах мэргэжилтэн; |
| 2.1.4. материал судлалын физикч. | 5.4. мал, амьтны дархлал судлаач; |
| 2.2. Хими: | 5.5. ургамлын генетикч; |
| 2.2.1. нефтийн технологич; | 5.6. хөдөө аж ахуйн экстейншний мэргэжилтэн; |
| 2.2.2. үнэт, ховор металлын түүхий эдийг гүн боловсруулах хими-технологийн инженер; | 5.7. байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн. |
| 2.2.3. эрдэс, биологийн гаралтай шинэ болон өгөгдсөн шинж чанар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх хими-технологийн инженер; | 6. Зам, тээврийн салбарт: |
| 2.2.4. полимерийн химийн инженер; | 6.1. гүүр байгуулалтын инженер; |
| 2.2.5. байгаль орчны хими-технологийн инженер; | 6.2. тунелийн инженер. |
| 2.2.6. биологийн идэвхт бодис гаргах, эм, биобэлдмэл үйлдвэрлэх мембраны технологийн инженер; | |
| 2.2.7. газрын тос боловсруулах үйлдвэрийн зураг төслийн болон үйлдвэрлэлийн процесс, аппаратурын инженер; | |
| 2.2.8. газрын тосны гүнзгийрүүлсэн боловсруулалтын физик, химийн инженер; | |
| 2.2.9. наноматериал судлаач. | |
| 2.3. Биологи: | |
| 2.3.1. генийн инженер; | |
| 2.3.2. эсийн инженер; | |
| 2.3.3. нанобиотехнологийн инженер; | |
| 2.3.4. молекулын биологич; | |
| 3. Мэдээлэл зүй, математикийн салбарт: | |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 178 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-ын 13-т "Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл санаачилсан Засгийн газрын гишүүн буюу аймаг, нийслэлийн Засаг дарга нь уг шийдвэрээр ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын саналыг албан бичиг, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, өөрийн байгууллагын вэб хуудсаар дамжуулан бичгээр болон цахим хэлбэрээр авсан байх шаардлагатай." гэсэн 2 дахь хэсгийг, журмын 34-т "Төлөвлөгөөнд ороогүй боловч хуралдаанаар зайлшгүй нэн яаралтай хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай асуудал гарвал хуралдаан хийхийн урьд өдөр ажлын цаг дуусахаас өмнө Ерөнхий сайд, Шадар сайдтай тохирсны үндсэн дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмэн оруулж болно." гэсэн 2 дахь хэсгийг, журмын 42-ын "л" заалтад "Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлын талаар Засгийн газрыг бүрдүүлж байгаа намууд зарчмын өөр байр суурьтай бол Ерөнхий сайд болон Шадар сайд нар харилцан тохиролцсоны үндсэн дээр түр завсарлага авч болно. Энэ тохиолдолд Ерөнхий сайд хуралдаан эхлэх хугацааг зарлана." гэсэн 2 дахь хэсгийг, 42-ын "м" заалтад "Засгийн газрын гишүүн хүндэтгэн зүгээ шалтгаангүйгээр хуралдааныг орхиж гарахыг хориглоно." гэсэн 2 дахь хэсгийг, журмын 47-д "Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаар гишүүд санал зөрөлдвөл шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Олонхийн санал авч чадаагүй бол шийдвэр гараагүйд тооцно." гэсэн 2 дахь хэсгийг тус тус нэмсүгэй.

2. Мөн журмын 3-ын "товлосноор буюу" гэсний дараа "Шадар сайд, эсхүл" гэж, 61-ийн 1 дэх өгүүлбэрийн "Хэрэг эрхлэх газрын" гэсний дараа "Хуулийн хэлтсийн дарга болон" гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 30-ийг "Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргахдаа Засгийн газрын нэг гишүүний эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэлэлцэж дуусгаад дараагийн гишүүний эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэлэлцэх, ингэхдээ уг асуудлыг хэлэлцэхэд олон хүн оролцож хугацаа ихээхэн шаардгдах улсын төсөв, Үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөө, боловсон хүчний зэрэг асуудлыг төгсгөл хэсэгт оруулах зарчмыг баримтална" гэж, журмын 39-ийг "Хуралдааныг Ерөнхий сайд даргална. Ерөнхий сайдын түр эзгүйд хуралдааныг Шадар сайд даргалах бөгөөд хэрэв Ерөнхий сайд, Шадар сайд нэгэн зэрэг түр эзгүй байвал Ерөнхий сайдын үүрэг болгосноор түүний үүргийг түр гүйцэтгэж байгаа Засгийн газрын аль нэг гишүүн хуралдааныг даргална" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

4. Мөн журмын 8-ын "д" заалтад "дангаар" гэснийг "Шадар сайдтай санал нэгдэж" гэж, 14, 16, 24-ийн "в", 24-ийн "г" заалтад "Санхүү, эдийн засгийн яам" гэснийг "Сангийн яам" гэж, 15-ын "Ерөнхий сайдаас" гэснийг "Ерөнхий сайд, Шадар сайдаас" гэж, 20-д "Холбогдох сайдаас" гэснийг "Холбогдох яам, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс" гэж, 29-д "Ерөнхий сайдад" гэснийг "Ерөнхий сайд болон Шадар сайдад" гэж, журмын 64-т "Ерөнхий сайдын хэвлэл мэдээлэл хариуцсан алба" гэснийг "Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба" гэж тус тус өөрчилсүгэй.

5. Журмын 42-ын "б" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Тогтоолын 2 дугаар хавсралтыг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Нэг. Дор дурдсан албан тушаалтан хуралдаанд заавал оролцоно:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтсийн дарга;

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга;

4. Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны дарга.

Хоёр. Дор дурдсан албан тушаалтан зөвлөх эрхтэйгээр холбогдох асуудлыг хэлэлцэх үед оролцоно:

1. Монгол банкны ерөнхийлөгч;

2. Монгол Улсын ерөнхий аудитор;

3. Төрийн албаны зөвлөлийн дарга;

- | | |
|--|---|
| 4. Үндэсний статистикийн газрын дарга; | 7. Ерөнхий сайдын ахлах зөвлөх; |
| 5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч; | 8. Шадар сайдын ахлах зөвлөх; |
| 6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх; | 7. Тогтоолын 3 дугаар хавсралтыг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай; |

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДЛЫН МАТЕРИАЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮРГҮҮЛЭХ
АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**

Нэг. Материал, төлөвлөгөөг бүрнээр хургуулэх: Хоёр. Төлөвлөгөө болон холбогдох материалыг хургуулэх:

- | | |
|---|---|
| 1. Монгол Улсын Ерөнхийлөгч; | 1. Төрийн албаны зөвлөлийн дарга; |
| 2. Монгол Улсын Их Хурлын дарга; | 2. Монгол банкны ерөнхийлөгч; |
| 3. Монгол Улсын Ерөнхий сайд; | 3. Монгол Улсын ерөнхий аудитор; |
| 4. Монгол Улсын Засгийн газрын гишүүд-17; | 4. Үндэсний статистикийн газрын дарга; |
| 5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга; | 5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч. |
| 6. Ерөнхий сайдын ахлах зөвлөх; | МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ |
| 7. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтсийн дарга; | МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БАЯРЦОГТ |
| 8. Засгийн газрын хэвлэл, мэдээллийн албаны дарга. | |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:** байгуулсан Хэлэлцээрийг баталсугай.

Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд 1996 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**
**ГАДААД ХЭРГИЙН
САЙД** **Ц.МӨНХ-ОРГИЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

"Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал"-д нэгдэн орох тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

3. Энэхүү Тунхаглалын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх асуудлаар Сэргээшийн эсрэг дэлхийн агентлагтай хамтарч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Гандид үүрэг болгосугай.

1. "Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал"-д Монгол Улс нэгдэн орохыг зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

2. "Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал"-д нэгдэн орох гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Эрүүл мэндийн сайд Т.Гандид олгосугай.

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД БӨГӨӨД
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Ц.БАЯРСАЙХАН**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад дср дурдсан 46 дахь заалт нэмсүгэй:

46	"Газрын харилцааны тэргүүний ажилтан"	Барилга, хот байгуулалтын сайд
----	---------------------------------------	--------------------------------

2. "Газрын харилцааны тэргүүний ажилтан" даалгасугай.
 тэмдэг олгох журам, загварыг баталж мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаярт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Н.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

2005 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан "Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Ч.УЛААН

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Г.БАТХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

2005 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан "Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.ТЭРБИШДАГВА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад дор дурдсан 47 дахь заалт нэмсүгэй:

1. "Засгийн газрын салбарын тэргүүний



47.	"Газрын тосны тэргүүний ажилтан" тэмдэг	Үйлдвэр, сайд	худалдааны
-----	---	---------------	------------

2. "Газрын тосны тэргүүний ажилтан" даалгасугай.
тэмдгийг олгох журмыг баталж мөрдүүлэхийг
Үйлдвэр, худалдааны сайд С.Батболдод

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД** Ч.УЛААН
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД** С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Дугаар 87 Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар томилсугай.
зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД** Ч.УЛААН

Түдэвийн Цэрэнпүрэвийг Түлш, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргаар

**ТҮЛШ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД** Т.ОЧИРХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Дугаар 88 Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД** Ч.УЛААН

Буян-Өлзийн Жаргалсайханыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Шударга бус

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД** Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Дугаар 93 Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, хуулийн 8.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 19 дүгээр хавсралт болгон дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Орлогч дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
- Гишүүд: -Сангийн сайд;
-Байгаль орчны дэд сайд;

- Барилга, хот байгуулалтын дэд сайд;
- Батлан хамгаалахын дэд сайд;
- Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд;
- Түлш, эрчим хүчний дэд сайд;
- Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
- Эрүүл мэндийн дэд сайд;
- Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга;
- Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан Засгийн газрын референт;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга / тохиролцооноор/;
- Монгол Улсын Их сургуулийн захирал;
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал;
- Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал;
- Шинжлэх ухааны академийн нийгмийн ухааны салбарын бага чуулганы дарга;
- Шинжлэх ухааны академийн физик, математик, химийн салбарын бага чуулганы дарга;
- Шинжлэх ухааны академийн геологи, газар зүйн салбарын бага чуулганы дарга;
- Шинжлэх ухааны академийн биологи, хөдөө аж ахуйн салбарын бага чуулганы дарга;
- Шинжлэх ухааны академийн анагаах ухааны салбарын бага чуулганы дарга;
- Шинжлэх ухааны академийн техник, технологийн салбарын бага чуулганы дарга.
- Нарийн бичгийн дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД П.ЦАГААН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 1